



**ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 05 сарын 03 өдөр

Дугаар A/15

Чингис хот

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйл, Хэнтий аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 2 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2017 оны байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэх Хэнтий аймгийн хэмжээнд ерөнхий агнуур зохион байгуулалт хийх, ногоон байгууламж байгуулах, Хэрлэн сумын ундны усны эх үүсвэрт хашаа барих ажлуудын худалдан авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Э.Мөнх-Эрдэнэ	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	И.Баасанжав	-Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
Гишүүд:	М.Шүрэнцэцэг	-Хэрлэн сумын Засаг даргын орлогч
	Б.Гүрсүрэн	-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн
	Б.Санчир	-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн
	Н.Оюунмандал	-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн
	Ч.Хос-Эрдэнэ	-Хэнтий аймгийн Иргэний нийгмийн байгууллагуудын сүлжээний тэргүүн

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Э.Мөнх-Эрдэнэ/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

03 079